



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОНХО-аар төлөвлөж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 41.9 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанартай бус хэт жижиглэсэн, байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээ эзэлж байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг бууруулж, хөрөнгө оруулалтын мөн чанарыг алдагдуулж байна

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2025/06-17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум

2025.05.23

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040, Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036, Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Баасансүрэн

Утас: 70362442, Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com

Аудитор Ж.Цогт

Утас: 70362442, Цахим хаяг: Tsogj@audit.gov.mn

Аудитор О.Анхбаяр

Утас: 70362442, Цахим хаяг: Ankhbayaro@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
1 дүгээр бүлэг: Орон нутгийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	5
1.1 Орон төсвийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж төлөвлөөгүй байна.	5
1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа нь сөрөг үр дагаврыг үүсгэж байна.	6
1.3 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна.	8
1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн төсөл, арга хэмжээг аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна	9
2 дугаар бүлэг: Аймгийн төсөвт 9 дүгээр сард хийгдсэн тодотголоор төсөл, арга хэмжээний тоог нэмэгдүүлэн баталснаас шалтгаалан 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.	11
2.1 Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж батлан эрх шилжүүлж байгаа нь худалдан авах ажиллагаа оройтох, улмаар төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэх, хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.	11
2.2 Захиалагч болох аймаг, сумдын Засаг даргын бус ашиглагч байгууллагын ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн 31 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.	13
2.3 Тайлант онд нийт 142 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион зохион байгуулагдсанаас 95.8 хувь буюу 136 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах эрх олгогдсон байна.	15
3 дугаар бүлэг: Тайлант онд комиссын актаар хүлээж авсан 1,030.6 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын бүртгэл тайланд тусгаагүй байна.	18
3.1 Тайлант онд 131 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг үндэслэн 12,513.6 сая төгрөгийн санхүүжилтийг хууль, журмын дагуу олгосон байна.	18
3.2 2024 онд хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний 26.6 хувь буюу 44 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.	21
3.3 Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь батлагдсан орон тооны дагуу архитектор болон барилгын инженерийг ажиллуулалгүйгээр барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.	23
3.4 Тайлант онд комиссын актаар хүлээж авсан 1,030.6 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд нь бүртгэл, тайланд тусгаагүй байна.	25
Илрүүлсэн зөрчил	26
Дүгнэлт	26
Зөвлөмж	27
Ирүүлсэн санал, тайлбар	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сумдын 2024 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт	5
Хүснэгт 2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангасан байдал	8
Хүснэгт 3	Улсын төсвийн байгууллагуудын өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	10
Хүснэгт 4	Тендерийн баримт бичгийг боловсруулсан байдал	13
Хүснэгт 5	Тайлант онд гүйцэтгэлийн баталгаагаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	19
Хүснэгт 6	Тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээж авсан боловч бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	25

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх, - Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх, - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, санхүүжилт, захиалагчийн хяналтыг зохион байгуулсан аймгийн ТЕЗ, ХААГ, ОНӨГ, аймаг, сумдын ЗДТГ, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ зэрэг холбогдох байгууллага болон төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн баримт материалуудыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ. Аудитад аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, аймгийн Худалдан авах ажиллагааны газар, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглаж, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа.Үүнд: - Төсвийн тухай хууль, - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,

	• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Барилгын тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • Авто замын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2023 оны А/261 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2023 оны 132 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө”, • Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт, • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт, О.Анхбаяр нар 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 5 дугаар сарын 23-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Ерөнхий мэдээлэл:	Аймаг, сумдын орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 7,288.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36, шинээр хэрэгжих 19,495.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 148 зэрэг нийт 26,783.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 184 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна. Аймаг, сумдын өмнөх оноос шилжин хэрэгжих 1,242.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 /өмнөх онд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй./, шинээр хэрэгжих 19,495.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 148 зэрэг нийт 20,738.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 153 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар” баталсан 02 дугаар тогтоолыг баримтлан зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар 19,430.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 182 төсөл, арга хэмжээ (2025 онд он дамжин хэрэгжих 7,353.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг хассан)-г төлөвлөснөөс 11,876.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 төсөл, арга хэмжээ бүрэн, 5,835.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 1,717.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Бүлэг 1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Орон нутгийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улс, орон нутгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн үү?

Орон төсвийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж төлөвлөөгүй байна

1.1.1 Сэлэнгэ аймаг болон сумдын орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 7,288.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36, шинээр хэрэгжих 19,495.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 148 зэрэг нийт 26,783.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 184 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав) Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 9,381.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 86 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталснаас 2,980.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих бол 6,400.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 71 нь шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ,
- 11 сумын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 17,402.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 98 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталснаас 4,307.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих бол 13,094.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 77 төсөл, арга хэмжээ нь шинээр хэрэгжих байна.

Сумдын 2024 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт № 1

/сая төгрөг/

№	Сумын нэр	Баталсан төсөл, арга хэмжээний	
		Тоо	Төсөвт өртөг
1	Баянгол	2	36.2
2	Ерөө	14	1,398.1
3	Мандал	8	1,591.2
4	Орхон	2	23.9
5	Сайхан	4	388.0
6	Сүхбаатар	29	2,901.0
7	Түшиг	10	613.9
8	Хүдэр	7	6,120.1

9	Шаамар	1	22.4
	Нийт дүн	77	13,094.8

Эх сурвалж: Сумдын 2024 оны ИТХ-ын тогтоолууд

1.1.2 Тухайн онд төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улс, орон нутгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг богино болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн, тэдгээрийн хэрэгжилтийг хангах зорилттой уялдуулан төлөвлөсөн байхаар зохицуулсан байдаг.

1.1.3 Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн зорилт, арга хэмжээтэй уялдаагүй 45, аймаг, сумын Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээтэй уялдаагүй 41 төсөл, арга хэмжээ (давхардсан тоогоор) -г төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна. Үүнд:

- “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн зорилт, арга хэмжээтэй уялдаагүй 20, “Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний зорилттой уялдаагүй 18 төсөл, арга хэмжээ (давхардсан тоогоор)-г аймгийн ИТХ-аар баталж, төлөвлөсөн.
- Баянгол, Ерөө, Мандал, Орхон, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Хүдэр зэрэг 8 сум нь “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн зорилттой уялдаагүй 25, сумын Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй 23 төсөл, арга хэмжээ (давхардсан тоогоор)-г төлөвлөсөн. (Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав)

1.1.4 Дээрхээс бусад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж төлөвлөсөн байна.

1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлсэн үү?

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа нь сөрөг үр дагаврыг үүсгэж байна

1.2.1 2024 онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлэх ажлыг огт хийгээгүй байгаа нь Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.1 дэх “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна” гэсэн заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/300 дугаар захирамжаар 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг төлөвлөх, холбогдох баримт материалыг нэгтгэх, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг аймгийн Засаг даргын орлогч даргаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан хэдий ч хэрэгжүүлэлгүйгээр 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр 6,400.6 сая төгрөгийн өртөг бүхий 71 төсөл, арга хэмжээг баталсан,
- Баянгол, Ерөө, Мандал, Орхон, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Хүдэр, Шаамар зэрэг 9 сум нь 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр 13,094.8 сая төгрөгийн өртөг бүхий 77 төсөл, арга хэмжээг баталсан гэх мэт.

1.2.2 Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, төлөвлөхгүй байгаа нь холбогдох хууль, эрхийн актыг зөрчсөн дараах сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Үүнд:

1. Аймаг, сумдын ОНХО-аар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 148 төсөл, арга хэмжээний 41.9 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанартай бус хэт жижиглэсэн буюу байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой нийт 1,326.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 төсөл, арга хэмжээ /аймаг 459.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18, сумд 867.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 төсөл, арга хэмжээ/ эзэлж байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг бууруулж, хөрөнгө оруулалтын мөн чанарыг алдагдуулж байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав) Тухайлбал:

- Аймаг тус бүр нь 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн тоног төхөөрөмж (Жавхлант сум), “Сургуулийн тоног төхөөрөмж /Шаамар сум, Дулаанхаан тосгон), 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл худалдан авах (Хушаат сум),
- Баянгол сум 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын ЗДТГ-т компьютер худалдан авах”, 16.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “ЗДТГ-ын өрөөний хаалгануудыг солих”,
- Ерөө сум тус бүр нь 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Түр хамгаалах байрны тоног төхөөрөмж”, “Түр хамгаалах байрны засвар”, 8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн үйлчилгээний киоск машин худалдан авах”,
- Орхон сум 3.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Байгалийн ургамал нөхөн сэргээх (Цөлжсөн газрыг нөхөн сэргээх ургамлын үр авах),
- Түшиг сум 35.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын өрсөлдөх чадварын судалгаа”, 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Телевизийн бичлэг”, 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хяналтын постын засвар, тохижилт”, 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хяналтын пост цахилгаанд холбох” 5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “ЗДТГ-ын эко ОО”,
- Хүдэр сум 28.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын ой зохион байгуулалт хийлгэх (Сумын ойн менежментийн төлөвлөгөө хийлгэх) 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “ЕБСургууль камержуулах” гэх мэт.

2. Сүхбаатар сумын 1 дүгээр багт төрийн үйлчилгээ үзүүлэх багийн байртай атал тус багийн үйл ажиллагаанд дахин байр худалдан авахаар аймгийн ОНХО-аар “Багийн хөгжлийн төвийн байр худалдан авах (Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээнд 350.0 сая төгрөг, Сүхбаатар сумын ОНХО-аар “Байрны засвар, шугам татах (Сүхбаатар сум, Хонгор морьт 1-р баг)” төсөл, арга хэмжээнд 250.0 сая

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

төгрөг зэрэг нийт 600.0 сая төгрөгийг төлөвлөж, тус тусын ИТХ-аар баталсан нь давхардсан, үр ашиггүй зарцуулалт болсон байна. Нөгөө талаас дээрх 2 эх үүсвэрээс төлөвлөсөн нийт 600.0 сая төгрөгөөр Сүхбаатар сумын нэгдүгээр багийн үйл ажиллагаанд зориулан шинээр барилга барих бүрэн боломжтой атал хуучин барилга худалдан авахаар төлөвлөж, баталсан байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт болсон байна гэж үзэж байна.

1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, урсгал зардлын тооцоололтой, төсөвлөлтийн бусад шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгасан уу?

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна

1.3.1 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹-т хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахаар зохицуулагдсан байдаг.

1.3.2 Тайлант онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 71 төсөл, арга хэмжээнээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй 5 төсөл, арга хэмжээ (зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй, техникийн тодорхойлолтыг боловсруулж, баталгаажуулаагүй зөрчлийг тайлангийн 1.4-т оруулсан болно.) -г төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангасан байдал

Хүснэгт № 2

/ сая төгрөг /

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан эсэх	Газрын зөвшөөрөл олгосон огноо	Техникийн нөхцөл олгосон огноо			
						Цахилгаан хангамж	Дулаан хангамж	Ус хангамж, ариутгах татуурга	Холбоо дохиолол
1	Аймгийн ОНХО	Инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэл /Баруунбүрэн сум/	100.0	Батлаагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Аваагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй
2	Аймгийн ОНХО	Автозамын засвар, шинэчлэл /Шаамар сум/	100.0	Батлаагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй
3	Аймгийн ОНХО	Инженерийн шугамын засвар /Сант сум/	80.0	Батлаагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Аваагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй
4	Аймгийн ОНХО	Гүний худаг гаргах /Хилийн цэргийн цагаан арал/	20.0	Батлаагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй
5	Хүдэр сумын ОНХО	Бага сургууль барих	5,967.0	Баталсан	2024.02.28	2024.05.13	2024.05.01	2024.05.16	2024.03.25
		Нийт дүн	6,267.0						

Дээрх хүснэгтээс үзэхэд:

- Аймгийн ОНХО-аар хэрэгжүүлэх их засвар, тохижилтын нийт 3,040.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 33 төсөл, арга хэмжээнээс 300.0 сая төгрөгийн

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.4², 3.5³ дахь заалтыг зөрчсөн байна.

- Аймгийн ОНХО-аар эрх бүхий байгууллагаас дулаан хангамжийн зөвшөөрлийг огт аваагүй 2 төсөл, арга хэмжээ (төсөвт өртгийн давхцалыг хасаж тооцсон)-г, Хүдэр сумын ОНХО-аар эрх бүхий байгууллагаас цахилгаан болон дулаан хангамж, ус, ариутгах татуурга, холбоо дохиоллын техникийн нөхцөл (2024 онд авсан)-ийг аваагүй 5,967.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

1.3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дээрх төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан нь ажлын явц, хэрэгжилт удаашрах, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх улмаар төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд ашиглалтад оруулах боломжгүй байдалд хүрэх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн төсөл, арга хэмжээг аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

1.4.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасныг мөрдөхөөр зохицуулагдсан байдаг.

1.4.2 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 71 төсөл, арга хэмжээнээс зураг, төсөв болон техникийн тодорхойлолт нь огт хийгдээгүй дараах 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 380.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Үүнд:

- Зураг, төсөв нь огт хийгдээгүй “Инженерийн шугам, сүлжээний засвар шинэчлэлт (Баруунбүрэн сум)” төсөл, арга хэмжээнд 100.0 сая төгрөг, “Авто замын засвар, шинэчлэл (Шаамар сум)” төсөл, арга хэмжээнд 100.0 сая төгрөг, “Инженерийн шугамын засвар (Сант сум)” төсөл, арга хэмжээнд 80.0 сая төгрөг, “Гүний худаг гаргах (Хилийн цэргийн цагаан арал)” төсөл, арга хэмжээнд 20.0 сая төгрөг,
- Техникийн тодорхойлолтыг огт боловсруулаагүй “Аймгийн нэгдсэн музейн үзмэрийг виртуал технологиор баяжуулах” төсөл, арга хэмжээнд 80.0 сая төгрөг зэрэг.

² Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектур батална.

³ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

⁴ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: 29¹.2.1. тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх.

1.4.3 Аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 148 төсөл, арга хэмжээнээс зураг, төсөв болон техникийн тодорхойлолт нь урьдчилан хийгдээгүй орон нутгийн төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгэсэн 45 төсөл, арга хэмжээ (*барилга байгууламж 1, их засвар, тохижилт 12, авто зам, дэд бүтэц 2, тоног төхөөрөмж худалдан авах 30*) -г хэрэгжүүлэхээр нийт 10,763.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна. (*Дэлгэрэнгүйг Хавсралт 1, 2-т харуулав.*) Үүнийг тодруулбал:

- **Аймгийн ОНХО-ын хувьд:** Шинээр хэрэгжих дээрх 71 төсөл, арга хэмжээнээс их засвар, тохижилтын ажлын зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 743.4 сая төгрөгийг, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг урьдчилан боловсруулж, захиалагч аймгийн Засаг даргаар баталгаажуулаагүй 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 2,664.4 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн,
- **Сүмдын ОНХО-ын хувьд:** Шинээр хэрэгжих нийт 77 төсөл, арга хэмжээнээс Мандал, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Хүдэр зэрэг сумд барилга байгууламж, их засварын ажлын зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 6,901.0 сая төгрөгийг, Мандал, Сайхан, Түшиг сумд тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг урьдчилан боловсруулж, захиалагч сумын Засаг дарга нараар баталгаажуулаагүй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 455.0 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, **зураг төсвөө батлуулсан**, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь “Улсын болон орон нутгийн төсөв, ... хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг хориглоно.” 13.3.3: “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.4.4 Аймгийн ОНХО-аар улсын төсвийн байгууллагуудын өмчлөлд шилжих 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 946.3 сая төгрөгийг төлөвлөж, аймгийн ИТХ-аар батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, **тухайн шатны төсөвт хамаарах** хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Улсын төсвийн байгууллагуудын өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

Хүснэгт № 3

/ сая төгрөг /

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг
1	Газар уснаа явагч завь (Аймгийн Онцгой байдлын газар)	2024	2024	149.8
2	Эталон тоног төхөөрөмж (Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс)	2024	2024	72.1
3	Жижүүрийн шуурхай удирдлагын нэгжийн тоног төхөөрөмж (Аймгийн Цагдаагийн газар)	2024	2024	72.9
4	Мөнгөн хараа чуулгын тоног төхөөрөмж (Мандал сум)	2024	2024	348.3

5	Гадаадын иргэн харьяатын албанд шаардлагатай тоног төхөөрөмж	2024	2024	98.2
6	Гадаадын иргэн харьяатын газрын Хойд бүс дэх газрын албан хэрэгцээнд автомашин	2024	2024	75.0
7	Аймгийн Нэгдсэн музейн үзмэрийг виртуал технологиор баяжуулах	2024	2024	80.0
8	Аймгийн авто тээврийн төвд зөөврийн пүү худалдан авах	2024	2024	20.0
9	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн шалны засвар	2024	2024	15.0
10	Аймгийн ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилгын засвар	2024	2024	15.0
Нийт дүн				946.3

Бүлэг 2

Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Аймгийн төсөвт 9 дүгээр сард хийгдсэн тодотголоор төсөл, арга хэмжээний тоог нэмэгдүүлэн баталснаас шалтгаалан 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна

2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж батлан эрх шилжүүлж байгаа нь худалдан авах ажиллагаа оройтох, улмаар төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэх, хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна

2.1.1 Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр 44.1 дэх “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэсэн заалтын дагуу “Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр болон 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрүүд тус тус баталсан байна.

2.1.2 Аймаг, сумдын өмнөх оноос шилжин хэрэгжих 1,242.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 /өмнөх онд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй/, шинээр хэрэгжих 19,495.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 148 зэрэг нийт 20,738.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 153 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртөгийн дээд хязгаар” баталсан 02 дугаар тогтоолыг баримтлан дараах аргуудаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг ерөнхий гэрээний аргаар,

- 190.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргаар,
- 15,022.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар,
- 4,586.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 863.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 49 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар байгуулах аргаар. /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав./

2.1.3 Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1⁵-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд шилжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

2.1.4 Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 276.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/52 дугаар захирамжаар Баянгол, Сайхан сумдад эрх шилжүүлсэн байна.

2.1.5 Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 180 дугаар тогтоолоор баталсан 1,578.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/467 дугаар захирамжаар 12 сумдын Засаг дарга нарт эрх шилжүүлсэн байна. Үүнд:

- Баруунбүрэн суманд 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Баянгол суманд нийт 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,
- Ерөө суманд нийт 182.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3,
- Жавхлант суманд 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Зүүнбүрэн суманд нийт 221.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4,
- Мандал суманд нийт 286.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5,
- Сант суманд 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Сайхан сум 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Түшиг сум нийт 210.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4,
- Хушаат суманд 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Цагааннуур суманд нийт 210.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3,
- Шаамар суманд нийт 115.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ зэрэг.

2.1.6 Тайлант оны эцсээр төсөвт тодотгол хийж шинээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн баталж байгаа нь эрх шилжүүлэх захирамж оройтож гарах, төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэх, хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна.

2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан уу?

Захиалагч болох аймаг, сумдын Засаг даргын бус ашиглагч байгууллагын ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн 31 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна

2.2.1 Аймгийн ОНХО-аар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г аймгийн Засаг даргын захирамжаар бус аймгийн ХААГ-ын даргын тушаалаар байгуулсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5⁶, 48.2.2⁷ дахь заалтуудыг зөрчсөн бол сумд нь сумын Засаг даргын захирамжаар “Үнэлгээний хороо”-г байгуулсан байна.

2.2.2 Сангийн сайдын 2023 оны А/258, А/259, А/260, А/261 дүгээр “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай” тушаалуудаар тендерийн баримт бичгийг боловсруулахаар зохицуулсан байдаг.

2.2.3 Дээрх тушаалуудаар батлагдсан жишиг баримт бичгүүдийг үндэслэн “Үнэлгээний хороо” нь ерөнхий гэрээний аргаар гүйцэтгэх 1, гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэх 2, шууд худалдан авах 49 зэрэг нийт 52 төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.

Хүснэгт №4. Тендерийн баримт бичгийг боловсруулсан байдал

Тушаалын дугаар	Жишиг баримт бичгийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг /сая төгрөгөөр/
А/258	Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	7	1,596.0
А/259	Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	21	13,006.1
А/260	Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	1	420.0
А/261	Харьцуулалтын аргаар бараа худалдан авах, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	72	4,586.9
Нийт		101	19,609.0

2.2.4 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна” гэж заасан байдаг.

2.2.5 Гэвч захиалагч болох аймгийн Засаг даргын бус ашиглагч байгууллагын ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн /сумдад эрх шилжүүлснээс бусад/ нийт 2,562.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын

⁶ Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.

⁷ үнэлгээний хороо байгуулах

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2.6 Сумдын хөрөнгө оруулалтын хувьд 1,703.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл, арга хэмжээнээс / үүнээс аймгаас сумдад эрх шилжүүлсэн 662.6 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ/ 630.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг сумдын Засаг даргаар бус ашиглагч байгууллагын ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн боловсруулсан байна. Үүнд:

- *Мандал сумын нийт 195.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3,*
- *Сайхан сумын 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,*
- *Сүхбаатар сумын 285.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5,*
- *Түшиг сумын 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ зэрэг.*

2.2.7 Аймгийн ОНХО-аар нь багийн нэг цэгийн үйл ажиллагаа болон иргэдийг худалдаа, үйлчилгээ явуулах нөхцөлийг хангах зориулалт бүхий 350.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий *“Багийн хөгжлийн байр худалдан авах”* төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод худалдаа, үйлчилгээний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах шаардлага/ *барилгын насжилт, дотоод засал, хийц, материал/-ыг тусгаагүй бөгөөд зөвхөн барилгыг худалдан авахаар гэрээ байгуулсан байна.*



/Багийн хөгжлийн төвийн зориулалтаар худалдан авсан барилгын гадна байдал - 2025.05.20/

2.2.8 Дээрхээс шалтгаалан барилгын засвар, халаалтын систем, цахилгааны монтаж зэрэг техникийн тодорхойлолтод тусгагдаагүй ажлыг гүйцэтгэхээр Сүхбаатар сумын ОНХО-аар 250.0 сая төгрөгийн өртөг бүхий *“Байрны засвар, шугам татах /1-р баг/”* нэршилтэй төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байна.

2.2.9 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх *“Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”* гэсэн заалт болон шинэчлэн батлагдсан тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу захиалагчид нь нийт 31 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн ТШЗ-37.1-т *“гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх шаардлагатай”* гэж тусгасан байна.

2.2.10 Харин дараах 6 төсөл, арга хэмжээнүүдийн тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгааны дүнг огт тооцоогүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг **тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана**” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- 859.3 сая төгрөгийн тухайн онд санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд гүйцэтгэлийн баталгааны 25.8 сая төгрөгийг тусгалгүйгээр зөвхөн гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ гэж зааж өгсөн, /Мөнгөн хараа чуулга ТТ, Спортын ордон мандал, Жавхлант цэцэрлэг/
- 443.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөнхий боловсролын сургуулийн засвар /Зүүнбүрэн сум/” төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд гүйцэтгэлийн баталгааны 13.3 сая төгрөгийг огт тусгаагүй,

Ерөө сумын хөрөнгө оруулалт:

- 1,151.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд гүйцэтгэлийн баталгааны 34.5 сая төгрөгийг огт тусгаагүй,

Сүхбаатар сумын хөрөнгө оруулалт:

- 2,175.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд гүйцэтгэлийн баталгааны 65.3 сая төгрөгийг огт тусгаагүй,

Түшиг сумын хөрөнгө оруулалт:

- 338.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн хатуу хучилттай болон хайрган хучилттай зам, бетонон хоолой тавих” төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд гүйцэтгэлийн баталгааны 10.2 сая төгрөгийг огт тусгаагүй,

Хүдэр сумын хөрөнгө оруулалт:

- 391.6 сая төгрөгийн тайлант онд санхүүжих дүнтэй “Бага сургууль барих” төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд гүйцэтгэлийн баталгааны 11.7 сая төгрөгийг огт тусгаагүй байна.

2.2.11 Гэрээ шууд байгуулах арга болон шууд худалдан авах аргаар гүйцэтгэснээс бусад нийт 19,158.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 98 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг цахим системд мэдээлсэн бөгөөд тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав/

2.3 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан уу?

Тайлант онд нийт 142 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 95.8 хувь буюу 136 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах эрх олгосон байна

2.3.1 Аймаг, сумдууд 2024 онд нийт 20,738.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 153 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар

төлөвлөснөөс 20,009.2 сая төгрөгийн өртөгтэй 142 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулсан байна. Үүнд:

- 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг ерөнхий гэрээний аргаар,
- 110.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргаар,
- 14,752.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар,
- 4,331.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 69 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 740.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар байгуулах аргаар гүйцэтгэсэн. /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав./

2.3.2 Тайлант онд ТБОНӨХБАУХА тухай хуулийн 35.1.2⁸ дахь заалт болон аймаг, сумын онцгой комиссын 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн хамтарсан хуралдааны шийдвэрийн дагуу 110.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн дээврийн засвар /Түшиг сум/” төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлсэн байна.

2.3.3 Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа хийлгэсэн, техникийн тодорхойлолтыг боловсруулаагүй болон хугацаа оройтож эрх шилжүүлснээс шалтгаалан тайлант онд гүйцэтгэх боломжгүй болсон нийт 753.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг огт зохион байгуулаагүй байна. Үүнд:

- Аймаг 390.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6,
- Ерөө сум 8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Сайхан сум 270.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Сүхбаатар сум 19.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Түшиг сум 65.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ гэх мэт

2.3.4 Аймгийн Засаг даргаас төсөл, арга хэмжээний эрхийг сумдад оройтож шилжүүлсэн болон шаардлага хангасан оролцогч ирээгүйгээс шалтгаалан нийт 704.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, гүйцэтгэгч шалгараагүй байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- Багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Баруунбүрэн сум/ - 80.0 сая төгрөг,
- Сургуулийн шугам сүлжээ засвар /Цагааннуур сум/ - 30.0 сая төгрөг,
- Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, сэргээн засварлах /Зүүнбүрэн сум/ 50.0 сая төгрөг,
- Зураг төсвийн зардал /Сүхбаатар сум Алтан намрын шим/ - 24.0 сая төгрөг,

Мандал сумын хөрөнгө оруулалт:

- ЕБ-ын сургуулиудын сурагчдыг тээвэрлэх автобус – 100.0 сая төгрөг,

⁸ онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй.

- *Мандал сумын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн иж бүрэн ажлын зураг төсөл, төсөв боловсруулах – 420.0 сая төгрөг зэрэг.*

2.3.5 Нийт 20,738.1 сая төгрөгийн 153 төсөл, арга хэмжээнээс 136 гүйцэтгэгчид 18,758.5 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгон, нийт 522.3 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүссэн байна. *(Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав)*

2.3.6 Захиалагч аймаг, сумдын Засаг дарга нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацаанд “Үнэлгээний хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсан боловч оролцогч санал ирүүлээгүй, ирүүлсэн санал нь шаардлага хангаагүй зэргээс шалтгаалж 35 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2-8 удаа зарлаж, тендер тус бүрд 13-208 хоног зарцуулсан байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав/*

2.3.7 Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан “Багийн хөгжлийн байр худалдан авах” төсөл, арга хэмжээнд ганц оролцогч буюу “Сэлэнгэ өсөх” ХХК-аас Сүхбаатар сумын 1 дүгээр багт байрлалтай, 1980-аад оны үед худалдаа, үйлчилгээний зориулалтаар ашиглалтад орж, хувьчлагдсан, чулуун хийцлэлтэй, төвлөрсөн дулааны шугамд холбогдоогүй, ашиглалтгүй орхигдсон хуучин барилгыг худалдах санал ирүүлснийг гүйцэтгэгчээр шалгаруулж, аймгийн ХААГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 92 дугаар албан бичгээр “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл”-ийг хүргүүлсэн байна.

2.3.8 Бид аудитын явцад худалдан авсан дээрх барилгыг газар дээр нь тулган шалгахад нам даралтын зуух нь эвдэрсэн, халаалтын шугам салгагдсан, цахилгааны монтаж болон дотор засварын ажил огт хийгдээгүй, шалыг дүүргэлт хийж цутгасан, ариун цэврийн өрөөгүй, үйл ажиллагаа явуулах эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилгыг худалдан авахаар шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн болох нь харагдаж байлаа.



/Багийн үйл ажиллагаа явуулах зориулалтаар худалдан авсан барилгын дотор байдал. 2025.05.20/

2.3.9 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ” гэсэн заалтын дагуу худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд оруулсан байна.

2.3.10 Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-3.1⁹-д заасны дагуу тайлагнаж, хагас жилийн болон жилийн эцсийн тайланг Сангийн яаманд цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

2.3.11 Тендер шалгаруулалттай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэлээр 8 аж ахуйн нэгжээс Сангийн яаманд өргөдөл, гомдол гаргаснаас 1 тендер шалгаруулалтын Үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй гэж дүгнэсэн бол 7 тендер шалгаруулалтыг хүчингүйд тооцож, дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- 4 тендер шалгаруулалтыг гомдол гаргасан аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхээр,
- 3 тендер шалгаруулалтыг хүчингүйд тооцож, худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

/Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав/

Бүлэг 3

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан уу?

Тайлант онд комиссын актаар хүлээж авсан 1,030.6 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын бүртгэл тайланд тусгаагүй байна

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн үү ?

Тайлант онд 131 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг үндэслэн 12,513.6 сая төгрөгийн санхүүжилтийг хууль, журмын дагуу олгосон байна.

3.1.1 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42.1¹⁰-д заасны дагуу Үнэлгээний хороо нь 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй **31** төсөл, арга хэмжээ (тайлант онд шинээр хэрэгжих 148 төсөл, арга хэмжээнээс 117 нь 3.9-100.0 сая төгрөгийн төсөвт

⁹ Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах хугацаанд ирүүлнэ. 3.1.1.Хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор, 3.1.2.Бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор.

¹⁰ Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100.0 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

өртөгтэй бөгөөд 2024 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.)-ний тендерийн баримт бичигт тусгасны дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх шаардлагыг тусгасан байна.

3.1.2 Тайлант онд санхүүжих 13,837.1 сая төгрөгийн өртөг бүхий **29** төсөл, арга хэмжээ (1 төсөл, арга хэмжээний ХАА-г 1 удаа зарлаж, шаардлага хангасан оролцогч ирээгүй тул гэрээ байгуулах эрх олгоогүй, 1 төсөл арга хэмжээний тендерийг огт зохион байгуулаагүй)-ээс **12** төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компаниудын өмнөөс ХААН, ХХБ, Голомт, Төрийн банк нь гүйцэтгэлийн баталгаа гаргасан байна.

3.1.3 Эдгээрээс гүйцэтгэлийн баталгааг 2024 онд санхүүжих дүнгийн 3 хувиас их болон бага дүнгээр тогтоосон дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- 137.6 сая төгрөгийн тайлант онд санхүүжих дүн бүхий “Иргэний танхимын тоног төхөөрөмж /Аймгийн ЗДТГ/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг 0.5 сая төгрөгөөр бага,
- 260.8 сая төгрөгийн тайлант онд санхүүжих дүн бүхий “Зуухны насос /Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг 1.2 сая төгрөгөөр их
- 182.2 сая төгрөгийн тайланд онд санхүүжих дүн бүхий “Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн гадна засвар /Мандал сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг 0.5 сая төгрөгөөр их гэх мэт.

3.1.4 Харин захиалагчид нь нийт 4,134.0 сая төгрөгийн тайлант онд санхүүжих дүн бүхий **17** төсөл, арга хэмжээний 124.0 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулалгүйгээр гэрээ байгуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5. Тайлант онд гүйцэтгэлийн баталгаагаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний үнийн дүн	Гүйцэтгэлийн баталгаа гаргавал зохих дүн
				Эхлэх	Дуусах					
1	Сэлэнгэ	Аймгийн улсын хяналтын байцаагчдын албан хэрэгцээнд автомашин	Тоног төхөөрөмж	2024	2024	199.5	199.5	Ачлалт төмөр хэлхээ ХХК, Хөтөл нутаг ХХК	194.5	6.0
2	Сэлэнгэ	Газар уснаа явагч завь /Аймгийн Онцгой байдлын газар/	Тоног төхөөрөмж	2024	2024	149.8	149.8	Протек ХХК	149.8	4.5
3	Сэлэнгэ	Мөнгөн хараа чуулгын тоног төхөөрөмж /Мандал сум/	Тоног төхөөрөмж	2024	2024	348.3	348.3	Протек ХХК	348.3	10.4
4	Сэлэнгэ	Багийн хөгжлийн төвийн байр худалдан авах /Сүхбаатар сум/	Тоног төхөөрөмж	2024	2024	350.0	350.0	Сэлэнгэ өсөх ХХК	350.0	10.5
5	Сэлэнгэ	Сургуулийн засвар /Баруунбүрэн сум/	Их засвар, тохижилт	2024	2024	138.9	138.9	Нарт оргил өргөө ХХК	138.9	4.2
6	Сэлэнгэ	Ариутгах татуургын шугамын засвар шинэчлэлтийн ажил /Ерөө, Бугант тосгон/	Их засвар, тохижилт	2024	2024	284.1	284.1	Сэлэнгэ ундрам ХХК	284.1	8.5

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

7	Сэлэнгэ	Спортын ордны барилгын засвар /Мандал сум/	Их засвар, тохижилт	2024	2024	289.9	289.9	Түрүү гарав ХХК	289.9	8.7
8	Сэлэнгэ	Сургуулийн дээврийн засвар /Түшиг сум/	Их засвар, тохижилт	2024	2024	110.5	110.5	Хүчит Сэлэнгэ ХХК	110.5	3.3
9	Сэлэнгэ	Залуучуудын хөгжлийн ордны дулааны шугамын ажил /Сайхан сум/	Их засвар, тохижилт	2024	2024	157.2	157.2	Онъ тэнгэрийн бичиг ХХК	157.2	4.7
10	Сүхбаатар	Явган хүний зам талбай, гарц, гэрэлтүүлэг, тохижилт	Авто зам, дэд бүтэц	2024	2024	310.0	310.0	Гурван гялаан ХХК	302.7	9.3
11	Сүхбаатар	Сүхбаатар сумын 3, 6 дугаар цэцэрлэг хашаа хийх	Их засвар, тохижилт	2024	2024	100.5	100.5	Есөн хэлхээ ХХК	94.4	3.0
12	Сүхбаатар	Хатуу хучилттай зам барих, гүүр засварлах, машины зогсоол хийх	Авто зам, дэд бүтэц	2024	2024	405.0	405.0	Сэлэнгэ АЗЗА	401.8	12.2
13	Сүхбаатар	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах	Их засвар, тохижилт	2024	2024	160.0	160.0	Арвайн шагшаа ХХК	155.2	4.8
14	Сүхбаатар	Байрны засвар, шугам татах /1-р баг/	Их засвар, тохижилт	2024	2024	250.0	250.0	Роуд дэвэллопмент ХХК	235.8	7.5
15	Сүхбаатар	"Гэрэлт цогцолбор"-засвар хийх	Их засвар, тохижилт	2024	2024	150.0	150.0	Сэлэнгэ ундрам ХХК	149.8	4.5
16	Түшиг	Сумын төвийн хатуу хучилттай болон хайрган хучилттай зам, бетонон хоолой тавих	Авто зам, дэд бүтэц	2024	2024	338.7	338.7	Эн би девелопмент ХХК	337.9	10.2
17	Хүдэр	Бага сургууль барих	Барилга байгууламж	2024	2025	5,967.0	391.6	Эко энержи ресурс ХХК	5,967.0	11.7
Нийт дүн						9,709.4	4,134.0		9,667.8	124.0

3.1.5 Төсөл, арга хэмжээний эхний болон явын санхүүжилтийг хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 30.0-80.0 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

3.1.6 Тайлант онд өмнөх оноос шилжин хэрэгжих 31, шинээр эхлэх 100 (2024 онд 163, 2025 онд 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан бол гүйцэтгэгч шалгараагүйгээс 19 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулаагүй) зэрэг нийт 131 төсөл, арга хэмжээний эхний болон явцын санхүүжилтийг олгосон байна.

3.1.7 2024 онд комиссын актаар хүлээж авсан 121 төсөл, арга хэмжээ (Өмнөх оноос шилжин хэрэгжсэн 24, 2024 онд шинээр эхэлсэн 97 төсөл, арга хэмжээ)-ний эцсийн санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.28¹¹, 4.8.29¹²-д заасны дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын ажлын хяналтын хуудас, гүйцэтгэлийн төсвийг үндэслэн захиалагч “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулж олгосон байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав)

3.1.8 Тайлант онд комиссын актаар ашиглалтад оруулсан 121 төсөл, арга хэмжээнээс 20-д нь чанарын баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож,

¹¹ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ болон худалдан авах төсөл зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан холбогдох маягтын дагуу бөглөж, баталгаажуулан ирүүлнэ.

¹² Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ.

хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулахаар гэрээнд тусгасны дагуу нийт 496.9 сая төгрөгийг байршуулсан байна.

3.1.9 Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/644 дүгээр захирамжийг үндэслэн он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан болон гэрээний хугацаанд ашиглалтад хүлээлгэж өгөөгүй төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилт болох нийт 214.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

3.1.10 Аймгийн ОНХО-ын төсөл, арга хэмжээний захиалагч нь өмнөх онд комиссын актаар хүлээж авсан, баталгаат хугацаанд чанарын гологдол гараагүй **17** төсөл, арга хэмжээний 107.5 сая төгрөгийн барьцааг чөлөөлж гүйцэтгэгч компаниудад шилжүүлсэн байна.

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн үү?

2024 онд хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний 26.6 хувь буюу 44 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

3.2.1 Захиалагчид нь тайлант онд шинээр эхлэх 148 төсөл, арга хэмжээ (7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй, 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаагүй, шууд гэрээ байгуулах 3 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлээгүй)-г хэрэгжүүлэхээр нийт 17,537.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.2 Өмнөх оноос шилжин хэрэгжих 36, шинээр эхлэх 148 зэрэг нийт 184 төсөл, арга хэмжээ (авто зам, дэд бүтцийн 25, барилга байгууламжийн 6, их засвар, тохижилтын 71, тоног төхөөрөмж 65, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ болон бусад 17) -г тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар нийт 24,592.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.3 Тайлант онд дуусгахаар гэрээ байгуулсан 163 төсөл, арга хэмжээнээс нийт 11,885.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 121 төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж комиссын актаар ашиглалтад хүлээн авч, 116 төсөл, арга хэмжээг “Гэрээ дүгнэсэн маягт”-аар баталгаажуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.4 Харин Сүхбаатар, Хүдэр сум нь тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээж авсан нийт 619.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй дараах 5 төсөл, арга хэмжээг “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулаагүй байна. Үүнд:

Сүхбаатар сум:

- 194.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хайрган хучилттай сайжруулсан зам, зогсоол барих /5, 7-р баг” төсөл, арга хэмжээ,

Хүдэр сум:

- 380.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Спорт зал гаднах засвар шилжих хөрөнгө”,
- 19.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Соёлын төвд хөгжим, тоног төхөөрөмж худалдан авах”,
- 15.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Спорт зал дэвжээ авах”,
- 10.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “ЕБСургууль камержуулах” зэрэг.

3.2.5 Худалдан авах ажиллагааг оны сүүлээр зохион байгуулсан, сумдын төсвийн орлогын төлөвлөгөө тасарснаас санхүүжилт бүрэн олгогдоогүй, төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд хүлээлгэж өгөөгүй зэргээс голлон шалтгаалж 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 23.1 хувь буюу 5,130.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 42 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.6 Тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн дараах 627.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжгүй хугацаанд буюу 11, 12 дугаар сард гэрээ байгуулснаас шалтгаалан он дамжин хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- 27.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Цэцэрлэгийн багш нарын тоног төхөөрөмж /Ерөө сум, Бугант тосгон/” төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 02 дугаар сарын 05,
- 68.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Цэцэрлэгийн тоног төхөөрөмж, тоглоом худалдан авах /Цагааннуур сум/” төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 02 дугаар сарын 18,
- 46.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй Сургуулийн тоног төхөөрөмж /Ерөө сум, Бугант тосгон/” төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 20,

Сүхбаатар сум:

- Сүхбаатар сумын 235.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Байрны засвар, шугам татах /1-р баг/” төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 08 дугаар сарын 01,
- Сүхбаатар сумын 149.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Гэрэлт цогцолборт засвар хийх” төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 06 дугаар сарын 10,
- Сүхбаатар сумын 100.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Гэрэлт гудамж тохижилт” төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 12 дүгээр сарын 31-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 05 дугаар сарын 15 гэх мэт.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дэх “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална.”, 13.1.4:“төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.7 Тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн 581.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 25 өдөр хүртэлх хугацаанд сунгасан байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- 49.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 01,
- 88.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Бага оврын экскаваторыг худалдан авах /Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ/” төсөл, арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15,
- 104.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Аймгийн ЗДТГ-ын өргөтгөлийн барилгын гадна фасадын засварын ажил” төсөл, арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 20,

Сүхбаатар сум:

- 155.2 сая төгрөгийн “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах /4 дүгээр баг 4-р хэсэг, 8 дугаар баг 5 дугаар хэсэг/” төсөл, арга хэмжээг 2025 оны 08 сарын 10,

Түшиг сум:

- 59.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт” төсөл, арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 20,

Хүдэр сум:

- 19.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Бэлчирийн гүүр барих ажил” төсөл, арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 25,
- 104.8 сая төгрөгийн “Сумын ой зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө хийлгэх” төсөл, арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 16 гэх мэт.

3.2.8 Ерөө сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1,386.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Бугант тосгонд асфальтан бетон хучилттай 3.97 км автозам барих” ажлын гүйцэтгэгч “Монгол туургатны зам ХХК” нь 500.0 сая төгрөгийн санхүүжилт авч, ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн үед дээрх батлагдсан төсөвт өртгөөр ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэх үндэслэлээр уг төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэхээс татгалзсан тул захиалагч гэрээг цуцалсан байна.

3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан уу?

Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь батлагдсан орон тооны дагуу архитектор болон барилгын инженерийг ажиллуулалгүйгээр барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна

3.3.1 Тайлант онд хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан 163 төсөл, арга хэмжээнээс нийт 11,885.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 121 төсөл, арга хэмжээ (авто зам, дэд бүтэц 16, барилга байгууламж 1, их засвар тохижилт 47, тоног төхөөрөмж 44, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ болон бусад 8) нь батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэнийг комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

3.3.2 Харин тайлант онд бүрэн хэрэгжсэн дээрх 121 төсөл арга хэмжээнээс 116-г нь “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулсан бол нийт 619.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй дараах 5 төсөл, арга хэмжээг “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулаагүй байна. Үүнд:

Сүхбаатар сум

- 194.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хайрган хучилттай сайжруулсан зам, зогсоол барих /5, 7-р баг/” төсөл, арга хэмжээ,

Хүдэр сум:

- 380.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Спорт зал гаднах засвар шилжих хөрөнгө”,
- 19.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Соёлын төвд хөгжим, тоног төхөөрөмж,
- 15.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Спорт зал дэвжээ авах” төсөл, арга хэмжээ,
- 10.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “ЕБСургууль камержуулах” зэрэг төсөл, арга хэмжээ.

3.3.3 “Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ” нь барилга байгууламж, их засварын өмнөх оноос шилжиж ирсэн 20, тайлант онд шинээр эхэлсэн 46 (тоног төхөөрөмж нийлүүлэх 47, зураг, төсөв, зөвлөх үйлчилгээний 8 зэрэг нийт 55 төсөл, арга хэмжээ хасагдсан) зэрэг нийт 66 төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4¹³, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12¹⁴-т заасны дагуу захиалагчийн хяналтыг гүйцэтгэж, холбогдох баримтуудаар баталгаажуулсан байна.

3.3.4 Гэвч тус ОНӨААТҮГ нь 2024 онд архитектор болон барилгын инженерийг батлагдсан орон тооны дагуу ажиллуулалгүйгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн болон он дамжин хэрэгжүүлж байгаа барилга байгууламж, их засварын 70 төсөл, арга хэмжээ (тайлант онд комиссын актаар ашиглалтад хүлээн авсан 49, он дамжин хэрэгжиж байгаа 21)-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн нь дээрх чиглэлийн хяналт дутуу хийгдэх, төсөл, арга хэмжээ чанарын шаардлага хангахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

3.3.5 Тайлант онд хэрэгжүүлсэн дээрх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлд ОНӨААТҮГ-ын дарга, дулааны болон цахилгааны инженерүүд нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн гэх үндэслэлээр захиалагчийн хяналтын тайлан, дүгнэлтийг баталгаажуулсан байна.

3.3.6 Тайлант онд хэрэгжүүлсэн дээрх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний үе шат бүрд Барилгын тухай хуулийн 37.1.5¹⁵, Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4¹⁶-т заасны дагуу зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулан, “Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт”-ээр баталгаажуулсан байна.

3.3.7 Тайлант онд бүрэн хэрэгжсэн техник, тоног төхөөрөмж худалдан авах нийт 3,142.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 47 төсөл, арга хэмжээнд аймаг болон

¹³ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

¹⁴ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

¹⁵ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

¹⁶ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сумдын ЗДТГ-ын ажлын хэсгүүд нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, “Тоног төхөөрөмж хүлээн авсан акт”-аар баталгаажуулан хүлээж авсан байна.

3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?

Тайлант онд комиссын актаар хүлээж авсан 1,030.6 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд нь бүртгэл, тайланд тусгаагүй байна.

3.4.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2¹⁷, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.30¹⁸-д заасны дагуу хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгахаар зохицуулсан байдаг.

3.4.2 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгосныг үндэслэн тайлант онд комиссын актаар хүлээж авсан 10,855.3 сая төгрөгийн 109 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.

3.4.3 Харин аймгийн болон Зүүнбүрэн, Сүхбаатар сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээн авсан нийт 1,030.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 12 төсөл, арга хэмжээг холбогдох байгууллагууд нь бүртгэл, тайланд тусгаагүй байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6. Тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээж авсан боловч бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгах байгууллага
1	Сэлэнгэ	Нийтийн эзэмшлийн байруудын засвар /Сүхбаатар, 7-р баг/	199.7	Орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй
2	Сэлэнгэ	12 айлын байрны дээвэр /Сант сум/	81.6	Орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй
3	Сэлэнгэ	16 айлын орон сууцны засвар /Сүхбаатар сум Ганзам 7-р баг/	46.8	Орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй
4	Зүүнбүрэн	Цэцэрлэгт хүрээлэнгийн зам, гэрэлтүүлэг тавих	92.3	Илдэнбүрэн ОНӨААТҮГ
5	Сүхбаатар	Явган хүний зам талбай, гарц, гэрэлтүүлэг, тохижилт	302.7	Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ
6	Сүхбаатар	Хайрган хучилттай сайжруулсан зам, зогсоол барих /5, 7-р баг/	194.3	Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ
7	Сүхбаатар	Хогийн сав худалдан авах /Ганзам 7-р баг/	28.0	Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ
8	Сүхбаатар	Сүхбаатар сумын түүхэн танилцуулга хийлгэх	6.0	Сүхбаатар сумын ЗДТГ

¹⁷ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ...

¹⁸ Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж, баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна.

9	Сүхбаатар	Сүхбаатар сум орчмын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө хийлгэх	20.0	Сүхбаатар сумын ЗДТГ
10	Сүхбаатар	ЕБ-н 5-р сургуулийн нам даралтын зуух шинэчлэх	19.3	Сүхбаатар сумын 5-р сургууль
11	Сүхбаатар	Сумын ЗДТГ-н байрны гадна талбайн зогсоол	20.0	Сүхбаатар сумын ЗДТГ
12	Сүхбаатар	1-р багийн Хоккейн талбайн тоног төхөөрөмж	19.9	Сүхбаатар сумын 5-р сургууль
Нийт дүн			1,030.6	

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **13,686.9** сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Албан шаардлага:

- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй нийт **11,143.8** сая төгрөг (*төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй 300.0 сая төгрөг, техникийн тодорхойлолтгүй 80.0 сая төгрөг, зураг төсөв, техникийн тодорхойлолт нь урьдчилан хийгдээгүй 10,763.8 сая төгрөг зэрэг*) -ийн өртөг бүхий 52 төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн,
- Аймгийн ОНХО-аар “Багийн хөгжлийн төвийн байр худалдан авах (Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 350.0 сая төгрөг, Сүхбаатар сумын ОНХО-аар уг байрыг “Байрны засвар, шугам татах /1-р баг/” нэршилтэйгээр барилгын засвар болон шугам татах ажлыг гүйцэтгүүлэхээр 250.0 сая төгрөг зэрэг нийт **600.0** сая төгрөгийн өртөг бүхий худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтод эрүүл ахуйн болон бусад шаардлагыг бүрэн тусгалгүйгээр худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн,
- Аймаг болон Сүхбаатар, Түшиг, Хүдэр сумд нь нийт 4,134.0 сая төгрөгийн тайлант онд санхүүжих дүн бүхий 17 төсөл, арга хэмжээний **124.0** сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулаагүй болон гэрээ байгуулах эрх олгохдоо 6 төсөл, арга хэмжээний **160.8** сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааны дүнг тооцоогүй.
- Аймаг болон Сүхбаатар сум нь 2024 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн нийт **627.7** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний гэрээг 11, 12 дугаар сард байгуулснаас шалтгаалан он дамжин хэрэгжихээр шийдвэрлэсэн.
- Нийт **1,030.6** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд тусгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр улс, орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулаагүй, эдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд урсгал зардлын шинж чанартай, хэт жижиглэсэн төсөл, арга хэмжээг тусган хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.
- Оны эцэст төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн баталсан, эрх шилжүүлэлт, худалдан авах ажиллагааг оройтуулсан зэргээс шалтгаалан төлөвлөсөн төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Захиалагч болох аймаг, сумдын Засаг дарга бус ашиглагч байгууллагын боловсруулсан техникийн тодорхойлолтыг үндэслэн боловсруулсан зарим төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт эрүүл ахуйн болон холбогдох бусад шаардлагыг бүрэн тусгаагүй байна.
- Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь архитектор болон барилгын инженергүйгээр барилга байгууламж, их засварын ажлын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа нь дээрх чиглэлийн хяналт дутуу хийгдэх, чанарын шаардлага хангахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.
- Комиссын актаар хүлээж авсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд бүрэн тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- Улс, орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн, хөрөнгө оруулалтын шинж чанарыг агуулсан төсөл, арга хэмжээг ОНХО-ын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх.
- ОНХО-ын төлөвлөгөөнд тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.
- ОНХО-ын төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулж, баталгаажуулах, худалдан авах ажиллагааны “Үнэлгээний хороо”-г Засаг даргын захирамжаар байгуулах замаар худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актад нийцүүлэх.
- Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн батлахгүй байх, худалдан авах ажиллагааны эрхийг тогтоосон хугацаанд

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

шилжүүлэх зэрэг үр нөлөө бүхий арга хэмжээг хэрэгжүүлж, төлөвлөсөн төсөл, арга хэмжээг тухайн онд нь багтаан ашиглалтад оруулах.

Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Октябрь-т:

- Ашиглагч байгууллагуудаас ирүүлсэн бус захиалагч болох аймгийн Засаг даргын баталсан техникийн тодорхойлолтыг үндэслэн тендерийн бичиг баримтыг боловсруулах, “Үнэлгээний хороо”-ны үйл ажиллагаанд хяналт тавих зэргээр худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Номин-д:

- Батлагдсан орон тоонд тусгагдсан мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлсний үндсэн дээр үр нөлөө бүхий захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Ж.ЦОГТ

О.АНХБАЯР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn


2025.05.23 № 01/679

танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тус тайлангийн төсөлд холбоотой саналгүй болно.



Н.Л.ХАГВАДОРЖ

432500807

C:\user\албан бичиг 2025\Засаг дарга жижиг тоот А5



Хавсралт 1

Барилга байгууламж, их засварын ажлын зураг, төсвийг урьдчилан хийлгээгүй болон орон нутгийн төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт нь багтаан зураг, төсвийг хийлгэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Хугацаа		Төсөвт өртөг	Зураг төсөл боловсруулж		
					Эхлэх	Дуусах		Эхэлсэн огноо	Дууссан огноо	Актын огноо, дугаар
Зураг, төсөв огт хийгдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт										
1	Сэлэнгэ	Инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэл /Баруунбүрэн сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	100.0	-	-	
2	Сэлэнгэ	Автозамын засвар, шинэчлэл /Шаамар сум/	Авто зам, дэд бүтэц	Шинэ	2024	2024	100.0	-	-	-
3	Сэлэнгэ	Инженерийн шугамын засвар /Сант сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	80.0	-	-	-
4	Сэлэнгэ	Гүний худаг гаргах /Хилийн цэргийн цагаан арал/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	20.0	-	-	-
Нийт дүн							300.0			
1	Сэлэнгэ	Сургуулийн засвар /Баянгол сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	77.4	2024.02.01	2024.02.10	2024.02.10
2	Сэлэнгэ	ЗДТГ-ын засвар /Баянгол сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	69.9	2024.03.05	2024.03.15	2024.03.15
3	Сэлэнгэ	Ариутгах татуургын шугамын засвар шинэчлэлтийн ажил /Ерөө, Бугант тосгон/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	284.1	2023.12.29	2024.05.03	2024.05.03
4	Сэлэнгэ	Сургуулийн дээврийн засвар /Түшиг сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	110.5	2024.09.30	2024.09.05	2024.09.05
5	Сэлэнгэ	Соёлын төвийн таазны засвар /Зүүнбүрэн сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	41.5	2024.09.01	2024.10.01	2024.10.01
6	Сэлэнгэ	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, сэргээн засварлах /Зүүнбүрэн сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	50.0	2024.09.25	2024.10.25	2024.10.25
7	Сэлэнгэ	Цэцэрлэгийн цонхны засвар, шинэчлэл /Сүхбаатар сум 2-р цэцэрлэг/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	60.0	2024.09.30	2024.10.07	2024.10.07
8	Сэлэнгэ	ЕБ-ын 3-р сургуулийн тохижилт шинэчлэлт /Мандал сум/	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	50.0	2024.01.20	2024.02.10	2024.02.10
9	Мандал	Хэрх ЕБС-ийн гал тогооны болон агааржуулалтын засварын ажил	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	45.3	2024.08.01	2024.09.08	2024.09.08
10	Сайхан	Түр хамгаалах байрны тохижилт	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	30.0	2024.03.05	2024.04.01	2024.04.01
11	Сайхан	Зам сайжруулах /Жимстэй хороолол, ЗДТГ-ын арын зам/	Авто зам, дэд бүтэц	Шинэ	2024	2024	270.0	2024.09.01	2024.11.01	2024.11.01
12	Сүхбаатар	"Гэрэлт цогцолбор"- засвар хийх	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	150.0	2024.05.19	2024.06.19	2024.06.19
13	Сүхбаатар	Гэрэлт гудамж тохижилт	Их засвар, тохижилт	Шинэ	2024	2024	100.0	2024.03.26	2024.04.26	2024.04.26
14	Түшиг	Сумын төвийн хатуу хучилттай болон хайрган хучилттай зам, бетонон хоолой тавих	Авто зам, дэд бүтэц	Шинэ	2024	2024	338.7	2024.06.17	2024.07.05	2024.07.05
15	Хүдэр	Бага сургууль барих	Барилга байгууламж	Шинэ	2024	2025	5,967.0	2024.04.18	2024.06.10	2024.07.03
Нийт дүн							7,644.4			

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн



Хавсралт 2

Техник, тоног төхөөрөмжийн техникийг тодорхойлолтыг огт боловсруулаагүй болон орон нутгийн төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт нь багтаан техникийн тодорхойлолтыг боловсруулсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Хугацаа		Төсөвт өртөг	Техник тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын хувьд	
					Эхлэх	Дуусах		Ашиглагчаас санал ирүүлсэн байдал	Техникийн тодорхойлолт боловсруулсан огноо
1	Сэлэнгэ	Аймгийн нэгдсэн музейн үзмэрийг виртуал технологгоор баяжуулах	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	80.0	Үгүй	Техникийн тодорхойлолтгүй
Орон нутгийн төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт нь багтаан техникийн тодорхойлолт боловсруулсан төсөл, арга хэмжээ									
1	Сэлэнгэ	Аймгийн улсын хяналтын байцаагчдын албан хэрэгцээнд автомашин	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	199.5	Тийм	2024.09.05
2	Сэлэнгэ	Хурлын танхимын тоног төхөөрөмж /Аймгийн ЗДТГ/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	58.0	Тийм	2024.03.27
3	Сэлэнгэ	Иргэний танхимын тоног төхөөрөмж /Аймгийн ЗДТГ/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	137.6	Тийм	2024.06.10
4	Сэлэнгэ	Газар уснаа явагч завь /Аймгийн Онцгой байдлын газар/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	149.8	Тийм	2024.04.08
5	Сэлэнгэ	Эталон тоног төхөөрөмж /Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	72.1	Тийм	2024.01.19
6	Сэлэнгэ	Цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Баянгол сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	49.9	Тийм	2024.01.20
7	Сэлэнгэ	Жижүүрийн шуурхай удирдлагын нэгжийн тоног төхөөрөмж /Аймгийн Цагдаагийн газар/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	72.9	Тийм	2024.05.13
8	Сэлэнгэ	Зуухны насос /Сэлэнгэ энэргэ ОНӨААТҮГ/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	260.8	Тийм	2024.01.29
9	Сэлэнгэ	Морь барианы хашаа /Аймаг/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	31.8	Тийм	2024.03.15
10	Сэлэнгэ	Усны машин /Сэлэнгэ Цэнгэг ус ОНӨААТҮГ/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	53.5	Тийм	2024.02.25
11	Сэлэнгэ	Мөнгөн хараа чуулгын тоног төхөөрөмж /Мандал сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	348.3	Тийм	2024.02.20
12	Сэлэнгэ	Терроризмтэй тэмцэх зөвлөлийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	100.0	Тийм	2024.03.05
13	Сэлэнгэ	Гадаадын иргэн харьяатын албанд шаардлагатай тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	98.2	Тийм	2024.01.31
14	Сэлэнгэ	Багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Баруунбүрэн сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	80.0	Тийм	2024.01.10
15	Сэлэнгэ	Гадаадын иргэн харьяатын газрын Хойд бүс дэх газрын албанд хэрэгцээнд автомашин	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	75.0	Тийм	2024.09.04
16	Сэлэнгэ	Багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Баянгол сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	50.0	Тийм	2024.02.25
17	Сэлэнгэ	Сумын Эрүүл мэндийг төвийн тавилга тоног төхөөрөмж худалдаж авах /Ерөө сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	100.0	Тийм	2024.10.31
18	Сэлэнгэ	Сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Зүүнбүрэн сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	50.0	Тийм	2024.03.19
19	Сэлэнгэ	Эрүүл мэндийн төвийн шүдний кабинетын тоног төхөөрөмж, тохижилт /Түшиг сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	50.0	Тийм	2024.05.05
20	Сэлэнгэ	Уурын зуухны тогоо худалдан авах /Зүүнбүрэн сумын Илдэнбүрэн ОНӨААТҮГ/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	80.0	Тийм	2024.11.05
21	Сэлэнгэ	Бохирын машин худалдан авах /Цэнгэг ус ОНӨААТҮГ/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	150.0	Тийм	2024.04.07
22	Сэлэнгэ	Сургуулийн тоног төхөөрөмж /Ерөө сум, Бугант тосгон/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	47.0	Тийм	2024.09.02
23	Сэлэнгэ	Багийн хөгжлийн төвийн байр худалдан авах /Сүхбаатар сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	350.0	Тийм	2024.02.19
24	Мандал	Цас хусагч 28 ковш	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	45.0	Тийм	2024.02.20
25	Мандал	Мандал шинэ агро техник ОНӨААТҮГ газарт трактор худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	50.0	Тийм	2024.03.10
26	Мандал	ЕБ-ын сургуулиудын сурагдыг тээвэрлэх автобус	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	100.0	Тийм	2024.01.08
27	Мандал	ЕБ-ын 3-р сургуулийн сурагчдын ширээ сандал худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	50.0	Тийм	2024.08.25
28	Сайхан	Иж бүрэн тайз худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	70.0	Тийм	2024.02.01
29	Түшиг	Соёлын төвийн лед дэлгэц	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	80.0	Тийм	2024.03.15
30	Түшиг	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Угсардаг тайз худалдан авсан/	Тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	60.0	Тийм	2024.03.15
Нийт дүн							3,119.4		